НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 15 өдөр Дугаар А/360 Улаанбаатар хот

「Сонгинохайрхан дүүргийн 12, 13-р хорооны」
"Алтанцэцүүхэй" өрхийн эрүүл мэндийн төвийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн есдүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сонгинохайрхан дүүргийн 12, 13-р хорооны "Алтанцэцүүхэй" өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 27 нэр төрлийн нийт 11,015,441.00 (арван нэгэн сая арван таван мянга дөрвөн зуун дөчин нэгэн) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 12,13-р хорооны " Алтанцэцүүхэй" өрхийн эрүүл мэндийн төв (Б.Хулан)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 20 нэр төрлийн нийт 5,155,641.00 (таван сая нэг зуун тавин таван мянга зургаан зуун дөчин нэгэн) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, 7 нэр төрлийн 5,859,800.00 (таван сая найман зуун тавин есөн мянга найман зуун) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 80,000.00 (наян мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 24,000.00 (хорин дөрвөн мянга) төгрөгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн 12,13-р хорооны "Алтанцэцүүхэй" өрхийн эрүүл мэндийн төвийн (Б.Хулан)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б. Оюмаа В.ОЮУМАА

9950501091

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны ... дүгээр сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 12, 13-р хороо "Алтанцэцүүхэй " ӨЭМТ

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгуулагын санал	мэргэжилтний санал	ҮХХХК-ын шийдвэр
1.Машин тоног төхөөрөмж													
1	Багаж ариутгагч	23	ш	1	69,647.00	69,647.00	69,647.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
2	Хэвлэгч	16	ш	1	150,000.00	150,000.00	150,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
3	Жингийн тавиур	16	ш	1	87,920.00	87,920.00	87,920.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
4	Утлагын аппарат	13	ш	1	190,250.00	190,250.00	190,250.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
5	Утлагын аппарат	15	ш	1	280,000.00	280,000.00	280,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
6	Хүүхдийн дуут жин	14	ш	1	159,000.00	159,000.00	159,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
7	Өндөр хэмжигчтэй жин	23	ш	1	44,140.00	44,140.00	44,140.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
8	Сандалтай хүүхдийн жин	13	ш	1	150,000.00	150,000.00	150,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
9	Ургын зүрх чагнагч	12	ш	2	236,000.00	472,000.00	472,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
10	Электрон халуун хэмжигч	11	ш	2	60,000.00	120,000.00	120,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
11	Пульсоксиметр /хүүхэд/	7	ш	1	200,000.00	200,000.00	200,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
12	Проектор	16	ш	1	1,100,000.00	1,100,000.00	1,100,000.00	-	эвдэрсэн	актлах		10,000	10,000
13	Утлагын аппарат	14	ш	1	280,000.00	280,000.00	280,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
14	Ургын зүрх чагнагч	14	ш	1	228,000.00	228,000.00	228,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
15	Электрон өндөр хэмжигч	13	ш	1	110,000.00	110,000.00	110,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
16	Зөөврийн компьютер	12	ш	1	1,350,000.00	1,350,000.00	1,350,000.00	-	эвдэрсэн	актлах		25,000	25,000
17	Лед дэлгэц	10	ш	1	530,000.00	530,000.00	530,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах

18	Шээсний шинжилгээний аппарат	9	ш	1	1,700,000.00	1,700,000.00	1,700,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
19	Өндөр хэмжигчтэй жин	14	ш	1	215,000.00	215,000.00	215,000.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
20	Эмэгтэйчүүдийн үзлэгийн ор	10	ш	1	850,000.00	850,000.00	850,000.00	-	эвдэрсэн	актлах		10,000	10,000
22	Компьютер дэлл i3	6	ш	1	1,529,800.00	1,529,800.00	1,529,800.00	-	эвдэрсэн	актлах		20,000	20,000
машин тоног төхөөремжийн дүн				23		**9,815,757.00**	**9,815,757.00**					65,000	65,000
2.Тавилга эд хогшил													
1	Өвчтөн зөөвөрлөх дамнуурга	23	ш	1	84,842.00	84,842.00	84,842.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
2	Өвчтөн зөөвөрлөх дамнуурга	23	ш	1	84,842.00	84,842.00	84,842.00	-	эвдэрсэн	актлах		устгах	устгах
3	Номын шкаф	16	ш	5	150,000.00	750,000.00	750,000.00	-	эвдэрсэн	актлах		5,000	5,000
4	Шкаф 8 хаалгатай	12	ш	1	130,000.00	130,000.00	130,000.00	-	эвдэрсэн	актлах		5,000	5,000
5	Эргэдэг сандал	16	ш	2	75,000.00	150,000.00	150,000.00	-	эвдэрсэн	актлах		5,000	5,000
тавилга эд хогшлын дүн				10		**1,199,684.00**	**1,199,684.00**					15,000	15,000
Нийт дүн						**11,015,441.00**	**11,015,441.00**	-				**80,000**	**80,000**
Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө						5,859,800.00							
Татан төвлөрүүлэх													
Устгах хөрөнгө						5,155,641.00							
Худалдсанаас олох орлого						80,000							
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/						24,000							